

Аудитын код: САГ-2018/94/СТА-ТӨХК

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Д.Цэгмиддорж
Утас: 261740 Цахим хаяг: tsegmiddorjd@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
“Пантер мидланд аудит” ХХК
Гүйцэтгэх захирал Д.Билэгсайхан
Утас: 70141770 94111770 Цахим хаяг: bilegsaikhan.d@pma.mn

Аудитор Ц.Алтанцэцэг
Утас: 99111770

Аудиторын туслах Ө.Зулцэцэг
Т.Пүрэвжав
А.Ариунболд
Х.Намуулин

“Пантер мидланд аудит” ХХК
Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Нарны зам -81 JS tower 1002 тоот.
Вэб хуудас: www.pma.mn
И-майл хаяг: info@pma.mn



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	1
2	Аудитын тайлан	3
2.1	Оршил.....	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	5
2.5	Дотоод хяналт	5
2.6	Орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга	6
2.7	Шилэн дансны мэдээлэл	7
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	7
2.9.1	Мөнгөн хөрөнгийн талаар.....	7
2.9.2	Авлагын талаар.....	7
2.9.3	Бараа материалын талаар.....	8
2.9.4	Биет бус хөрөнгийн талаар	8
2.9.5	Борлуулалтын буцаалтын талаар	8
2.9.6	Эздийн өмчийн талаар.....	8
2.9.7	Мөнгөн хөрөнгийн талаар.....	9
2.9.8	Авлагын талаар.....	9
2.9.9	Бараа материалын талаар.....	10
2.9.10	Өр төлбөрийн талаар	10
2.9.11	Зардлын талаар.....	11
2.9.12	Санхүүгийн тайлангийн талаар.....	11
2.9.13	Цалин хөлсний талаар	11
2.9.14	Үндсэн хөрөнгийн талаар	12
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	12
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	12
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	13
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	13
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3	Менежментийн захидал	14
3.1	Мөнгөн хөрөнгийн талаар	15
3.2	Авлагын талаар.....	16
3.3	Цалин хөлс, ХХОАТ, НДШ-ийн талаар.....	17
3.4	Бараа материалын талаар	18
3.5	Зардлын талаар	19
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	20

4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	20
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	21
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	22
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	23

1 Аудитын гэрчилгээ

ШИВЭЭ-ОВОО” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.ЭНХТҮВШИН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Шивээ-Овоо” ТӨХК-ийн 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2017 оны оны жилийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Аудитын гол асуудал

2017 оны жилийн эцсийн байдлаар 1,847.6 сая төгрөгийн дансны авлага, 13,844.5 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тулган баталгаажуулж, тооцоо нийлээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д *“өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх”* гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

“Шивээ-Овоо” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, авлага, өглөгийн тооцоог барагдуулж, тооцоо нийлж байх, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэн гаргах, нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад ашигласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газрын захиалгаар “Пантер Мидланд Аудит” ХХК аудитыг хийж гүйцэтгэлээ. САГ-/2018/94/СТА-ТӨХК

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хуулийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго байв.

“Шивээ-Овоо” ТӨХК нь санхүүгийн үйл ажиллагаагаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС, Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж байгууллагад мөрдөх санхүүгийн тайлан, түүний тодруулгын маягт бэлтгэх заавар”, Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 191 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягт, түүнийг хөтлөх аргачлал”, Нягтлан бодох бүртгэлийн бодлого, компанийн хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар баталсан Компанийн хурлаар баталсан Аудитын санхүүгийн тайлан бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж

материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 23-наас 2018 оны 3 дугаар сарын 10-ны хугацаанд нийт 30 хоног буюу 180 хүн өдөр ажиллахаар төлөвлөн “Пантер Мидланд Аудит” ХХК-ийн аудитор Д.Билэгсайхан, Ц.Алтанцэцэг, аудиторын туслах Т.Пүрэвжав, Ө.Зулцэцэг, А.Ариунболд, Х.Намуулин нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Шивээ-Овоо” ТӨХК нь 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 2а/92 тоот албан бичгээр “Пантер мидланд аудит” ХХК-д хугацаа хоцроож ирүүлсэн байна.

“Пантер мидланд аудит” ХХК нь жилийн эцсийн аудитыг 2018 оны 2 дугаар 26-наас 2018 оны 3 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, “Шивээ-Овоо” ТӨХК-ийн удирдлагад гардуулна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин


“Шивээ-Овоо” ТӨХК нь санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компанийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжид мөрдөх санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”, Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 14 тоот тогтоол “Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийн тооцоог хянах тухай”
- “Шивээ овоо” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 2 дугаар сарын 24-ны өдрийн 01 тоот тогтоол “Нүүрсний үнийг шинэчлэн тогтоох тухай”
- “Шивээ овоо” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 11 тоот тогтоол “Бүтэц, орон тоог батлах тухай”

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.



2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох бусад хуулийг шалгуур болгон ашигласан болно.

Аудитаар “Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж, аудитын явцад баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, бараа материал, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, урьдчилж гарсан зардал, тооцоо, орлого, зардал зэргээс томоохон дүнтэй, их гүйлгээтэй дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2016 онд “Голден пэйж аудит” ХХК-иар боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрддөг. 2017 оны эхний хагас жилд “Шивээ-овоо” санхүүгийн програм, сүүлийн хагас жилд “Silicon 2” санхүүгийн програмуудыг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэсэн байна.

Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-иас боловсруулан өгсөн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй нийцээгүйгээс гадна шинээр авсан санхүүгийн програмтай уялдаагүй байна.

Төлөвлөлтөөр “Шивээ-Овоо” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд дунд буюу эрсдэлтэй гэж тооцсон ч талбарын ажлын үед мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн тогтоосон тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 2 хувиар буюу 1,037.5 сая төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн шатанд өөрчлөөгүй болно.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Шивээ-Овоо” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалтгүй үзсэн. Учир нь “Шивээ овоо” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 11 тоот “Бүтэц, орон тоог батлах

тухай” тогтоолын дагуу Дотоод аудитын албыг татан буулгаж, орон тооны цомхотгол хийсэн байна.

2.6 Орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга

2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлт дараах байдалтай байна.

2017 оны уулын ажлын төлөвлөгөөнд 1,950.0 мянган тонн нүүрс олборлож борлуулахаар тооцсон байна. Тайлант хугацаанд 2,020.3 мянган тонн нүүрс олборлож борлуулсан байна. Энэ нь өмнөх жилээс 3.9%-иар, төлөвлөснөөс 4.5%-иар нэмэгдсэн байна.


Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2016 оны гүйцэтгэл	2017 оны төлөвлөгөө	2017 оны гүйцэтгэл	Хэлбэлзэл төл-с %	2017 гүйцэтгэл 2016 гүйц %
А. Уулын ажлын үзүүлэлт							
1	Нүүрс борлуулалт	м.тн	1,880.9	1,950.0	2,020.3	103.6	107.4
2	Нүүрс олборлолт	м.тн	1,961.4	1,950.0	2,037.0	104.5	103.9
3	Тээвэртэй хөрс хуулалт	м.м³	5,427.7	6,313.0	5,360.3	84.9	98.8
4	Тээвэргүй хөрс хуулалт	м.м³	1,786.8	1,907.6	1,834.2	96.2	102.7
5	дахин шидэлт	м.м³	2,033.7	3,177.7	3,229.5	101.6	158.8
6	Нийт хөрс хуулалт	м.м³	7,214.5	8,220.6	7,194.6	87.5	99.7
7	Инженер ажил	м.м³	663.4	1,533.4	1,047.7	68.3	157.9
8	Нийт уулын цул	м.м³	11,532.6	13,219.0	13,155.2	99.5	114.1

Нийт орлого, зардлын бүтэц

Үзүүлэлтүүд	2016 оны гүйцэтгэл	2017 оны	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт орлого	45,898,111.70	47,969,452.70	51,877,304.90
Үндсэн үйл ажиллагааны орлого	42,752,185.40	47,826,452.70	49,373,804.60
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	3,145,926.30	143,000.00	2,503,500.30
Нийт зардал	43,807,841.50	47,965,997.20	51,351,882.60
Борлуулсан барааны өртөг	35,177,815.30	44,060,776.50	41,751,249.10
Борлуулалт маркетингийн зардал	0.00	0.00	1,493,640.00
Ерөнхий удирдлагын зардал	2,842,753.60	2,835,154.00	3,832,462.20
Үйл ажиллагааны бусад зардал	1,179,560.50	1,070,066.70	557,611.00
Санхүүгийн зардал	4,189,150.60	0.00	3,653,420.70
Ханшийн зөрүүний алдагдал	186,309.30	0.00	0.00
Татварын зардал	232,252.20	0.00	63,499.60
АШИГ	2,090,270.20	3,455.50	525,422.30

Тайлант жилд нийт борлуулалтын орлого 51,877.3 сая төгрөг. Үүнээс үндсэн үйл ажиллагаанаас 49,373.8 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагаанаас 2,503.5 сая төгрөгийн орлого тус тус олсон байна. Нийт орлого өмнөх оноос 5,979.2 сая төгрөг буюу 13.0%-иар, төлөвлөснөөс 3,907.9 сая төгрөг буюу 8.1%-иар өссөн байна.

Нийт зардал 51,351.9 сая төгрөгт хүрч өмнөх оноос 7,544.1 сая төгрөг буюу 17.2%-иар, төлөвлөсөнөөс 7.0%-иар буюу 3,385.9 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Зардал хэтэрсэн шалтгаан нь 2017 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй ус төрийн аудитын байгууллага мөн борлуулалтын орлого тодотголд тусгагдсан зардлууд гарсан байна.



Тайлант жилд 3.4 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөж 525.4 сая төгрөгийн ашигтай ажилласан гэж тайлагнасан боловч аудитын явцад залруулагдаж нийт ашиг 240.5 сая төгрөг болсон.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу www.shilendans.gov.mn-д хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 6 төрлийн мэдээллийг оруулсан байна.

Шилэн дансны тухай хуульд заасан цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ нь 2016 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн ажиллахгүй болсон тул энэ талаар Сангийн яамны санхүүгийн мэдээллийн технологийн хэлтэст 2017 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 1/596 тоот албан бичгээр албан ёсны тодруулга, шийдвэрийг хүссэн албан тоот илгээсэн боловч тус хэлтсээс албан ёсны хариу ирүүлээгүй гэсэн үндэслэлээр 2017 оны зорилтот түвшин болон бүх харилцах данс, төлөөлөгчийн газрын харилцах дансны 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг оруулаагүй байна.

Байгууллагын цахим хуудсанд компанийн мэдээлэл, холбогдох журам, заавар, нийгмийн хариуцлагын талаар хийсэн ажил, үйл ажиллагааны цаг үеийн мэдээ, мэдээллийг оруулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 29 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Мөнгөн хөрөнгийн талаар

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг арилжааны банк тус бүрээр тулган баталгаажуулалт хийхэд Төрийн банкны төгрөгийн данс нь 4.0 сая төгрөгөөр зөрсөн бөгөөд жолоочийн хариуцлагын даатгалд төлсөн төлбөрийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй байсан, валютын данснаас дансны шимтгэлийг хасч тооцоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “*Нягтлан бодох бүртгэлд бүх ажил гүйлгээг заавал бүртгэнэ*” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2.9.2 Авлагын талаар

- ✓ Дансны авлагад найдваргүй авлагын нөөцийн хасагдуулга 3,191.0 сая төгрөгийг оруулан тайлагнаж, дансны авлагын бодит үнэ цэнийг бууруулсан
- ✓ Санхүүгийн тайланд Нэмэгдсэн өртгийн албан татварын бодон Хувь хүний орлогын албан татварын 1,432.5 сая төгрөгийн авлага, өлгийг тохируулах бичилтийг хийгээгүй.

Энэ нь авлагыг бодит үнэ цэнээр бүртгэх, санхүүгийн тайлангийн бодитоор байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2.9.3 Бараа материалын талаар

Эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар сэлбэгийн данснаас Урьдчилж гарсан зардал дансанд 669.0 сая төгрөгийг шилжүүлэн бүртгэсэн.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар батлагдсан журмын заалт болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2.9.4 Биет бус хөрөнгийн талаар

Биет бус хөрөнгө дансанд бүртгэгдэх үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 30.1 сая төгрөгийн програм хангамжуудыг хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө дансанд бүртгэсэн.

Энэ нь Сангийн сайдын 77 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтанд заагдсан ангилалтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2.9.5 Борлуулалтын буцаалтын талаар

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн лаборатори болон пүү нь зөвшөөрөгдсөн стандарт хэмжил зүйн шаардлагыг хангаагүй гэж үздэг учир гол хэрэглэгч болох “ДЦС-4”, “Налайх Дулааны станц”, “Амгалан дулааны станц” зэрэг байгууллагуудтай хийсэн гэрээний дагуу жингийн болон илчлэгийн зөрүүг тооцдог бөгөөд санхүүгийн тайланд борлуулалтын буцаалтыг 311.6 сая төгрөгөөр дутуу тооцсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд бүх ажил гүйлгээг заавал бүртгэнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2.9.6 Эздийн өмчийн талаар

Санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө, нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн 0.1 сая төгрөгөөр зөрж байгаа ба энэ нь программын хаалтыг дутуу хийснээс үүссэн



Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэл нь үнэн зөв байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2.9.7 Мөнгөн хөрөнгийн талаар

Хас банкны 5000094701 тоот төгрөгийн, Төрийн банкны 30030008438 тоот төгрөгийн, 341033090506 тоот төгрөгийн, 34130322697 тоот ам.долларын, 300300131348 тоот рублийн дансууд аж ахуйн нэгжийн гэрчилгээнд тэмдэглэгдээгүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “хуулийн этгээд нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан бүртгэлийн мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аж ахуйн нэгжийн гэрчилгээнд банкинд шинээр нээсэн дансуудыг тэмдэглүүлэх талаар зөвлөмж өгөв.

2.9.8 Авлагын талаар

- ✓ Авлагыг Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын дагуу ангилаагүй.
- ✓ Өмнөх оны авлагын үлдэгдлийг барагдуулаагүй нийт 21 харилцагч байгууллагын 560.6 сая төгрөг /хавсралтаар/-ийн авлага байна.
- ✓ Найдваргүй авлагын нөөц данс нь 3,191.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд өмнөх жилүүдэд борлуулалтын орлогын дүнгээс тодорхой хувиар тооцож хуримтлуулан бүртгэдэг байсан байна. Шүүхийн шийдвэртэй 320.1 сая төгрөгийн авлага байгаа боловч барагдуулах арга хэмжээг аваагүй байна.
- ✓ Урьдчилж гарсан зардал дансанд өмнөх тайлант жилд үүссэн 37 аж ахуйн нэгжийн 409.3 сая төгрөг /хавсралт/-ийн урьдчилж төлсөн тооцоог барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж тус тус заасныг, мөн Сангийн сайдын 249 дүгээр тушаалын заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, заавар журмыг мөрдөж ажиллах, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, төлөгдөөгүй авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах, төлөгдөх боломжгүй авлагын судалгааг хийж, зөв бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх, санхүүгийн тайланд тусгасан татварын тайлангийн үлдэгдлүүдийг харьяа татварын хэлтэстэй тооцоо нийлж баталгаажуулах, алдааг эгзүүлсэн тайлангуудыг дахин тайлагнах зэрэг асуудлаар зөвлөмж өгөв.

2.9.9 Бараа материалын талаар

- ✓ Бараа материалын нэр төрлөөрх дэлгэрэнгүй тайланг шалгахад хасах үлдэгдэлтэй бараа материал их байна. Энэ нь эд хариуцагч болон нягтлан бодогчид санхүүгийн програмд хасалт хийхдээ нэр төрлийн кодыг зөрүүлж бүртгэснээс шалтгаалсан байна.
- ✓ Тайлант онд хөдөлгөөн хийгдээгүй 7,271.0 сая төгрөгийн сэлбэг, бараа материал байгаа бөгөөд энэ нь нийт бараа материалын 56.4%-ийг эзэлж байна. Ашиглагдахгүй байгаа сэлбэг, бараа материалыг худалдан борлуулахаар туршин үзсэн бөгөөд зохих үр дүнд хүрээгүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.2-т заасан “бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэцэглэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх” гэж заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Компанийн тухай хууль, холбогдох стандарт, заавар журам, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөх, санхүүгийн тайланд тусгагдсан бараа материалын үлдэгдлийг дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгаж зөрүү гарсан бол санхүүгийн тайлан батлагдахаас өмнө залруулж, үлдэгдлийг тохируулж байх, эд хариуцагч болон санхүүгийн ажилчдын ур чадварыг нэмэгдүүлэх зэрэг зөвлөмж өгөв.

2.9.10 Өр төлбөрийн талаар

- ✓ Цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлан” /ТТ-11/ болон “Суутгагчийн хувь хүнд олгосон орлогын албан татварын тайлан” /ТТ-12/ маягтаар тайлагнадаг. Нийт суутгасан 814.1 сая төгрөгийн татвараас дээрх 2 тайлангаар 795.8 сая төгрөгийн татвар тооцоолж 18.3 сая төгрөгийн татварын ногдуулалтыг дутуу тайлагнасан байна.
- ✓ Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлангийн эхний үлдэгдэл санхүүгийн тайлангийн үлдэгдлээс 40.1 сая төгрөгөөр зөрсөн.
- ✓ Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 52.9 сая төгрөг, Ус ашигласны төлбөр 4.8 сая төгрөг, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 39.9 сая төгрөг, Хувь хүний орлогын албан татварын өглөг 3.6 сая төгрөгөөр тус тус татварын тайлангийн үлдэгдлээс зөрсөн.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2-д “Энэ хуулийн 24.1-т заасан хөнгөлөлтийг хасч, холбогдох төсөвт шилжүүлнэ” гэж заасныг зөрчсөн ба мөн санхүүгийн тайлангийн үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, заавар журмыг мөрдөх, санхүүгийн тайланд тусгасан татварын тайлангийн үлдэгдлүүдийг харъяа татварын хэлтэстэй тооцоо нийлж баталгаажуулах, алдаатай гарсан тайлангуудыг дахин тайлагнах зэрэг асуудлаар зөвлөмж өгөв.



2.9.11 Зардлын талаар

Нийт зардал 51,351.9 сая төгрөгт хүрч өмнөх оноос 7,544.1 сая төгрөг буюу 17.2%-иар, төлөвлөсөнөөс 7.0%-иар буюу 3,385.9 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Зардал хэтэрсэн шалтгаан нь 2017 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй ус шүүрүүлэх Д шугамын төслийн ажлыг хийж гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

Удирдлагын зардал өмнөх жилээс 811.0 сая төгрөгөөр, төлөвлөгөөнөөс 818.6 сая төгрөгөөр хэтрэлттэй байна. Зардал хэтэрсэн шалтгааныг компанийн зүгээс борлуулалтын орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор төлөвлөгдөөгүй болон тодотголд тусгагдсан зардлууд гарсан гэж компанийн зүгээс тайлбар өгсөн. 2017 оны бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан боловч Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл ийн 21.1-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид “зорилтын санал” гэх/-ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”, Компанийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.5.9 “Гүйцэтгэх удирдлагаас боловсруулсан компанийн ирэх санхүүгийн жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, нэмэлт өөрчлөлт оруулан шийдвэрлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн бизнес төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд, компанийн дүрэмд заасныг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөв.

2.9.12 Санхүүгийн тайлангийн талаар


“Шивээ-Овоо” ТӨХК нь 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 2а/92 тоот албан бичгээр “Пантер мидланд аудит” ХХК-д хугацаа хоцроож ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэх...” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2.9.13 Цалин хөлсний талаар

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн ажилчдын ээлжийн амралтын тэмдэж цалин хөлсөнд хоолны хөнгөлөлтийг оруулж тооцсоны улмаас 18.5 сая төгрөгийн ээлжийн амралтын мөнгийг илүү олгосон зөрчил үүсгэсэн байна.



Энэ нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаал “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2.9.14 Үндсэн хөрөнгийн талаар

- ✓ Тайлант онд үндсэн хөрөнгө 5,223.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 2,162.5 сая төгрөгөөр хасагдсан байна. Үндсэн хөрөнгө актлах, шинээр худалдан авахдаа “Шивээ-овоо” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, Хувь нийлүүлэгчдийн хурлын тогтоолыг үндэслэсэн байна.

Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.8-д заасан *“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах эрхтэй”* гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ


“Шивээ-Овоо” ТӨХК-д дараах анхаарал татахуйц чухал асуудлууд байна. Үүнд:

- ✓ Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудит хийгдсэн үлдэгдлийг Сангийн яамны www.e-balance.mn -д шивэгдсэн тайлантай тулгаж үзэхэд 2016 оны санхүүгийн аудитаар залруулагдсан буюу Засгийн газрын нэгдсэн тайланд орсон тайлангаас зөрсөн.
- ✓ Санхүүгийн тайлангийн уялдааг шалгадаггүй.
- ✓ Дотоод хяналт сул
- ✓ Санхүүгийн програм болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дансны нэгдсэн жагсаалт, ангилал нь хоорондоо зөрүүтэй.
- ✓ “АСЕМ”-ийн дээд хэмжээний уулзалтанд хэрэглэсэн БНСУ-д үйлдвэрлэгдсэн “Hyundai universe Luxury” маркийн 45 хүний суудалтай 2 ширхэг автобусыг “Ди Би Эм лизинг” ХХК-иас 486.0 сая төгрөг /10 жилийн хугацаатай, жилийн 4.5%-ийн хүүтэй/-өөр худалдан авсан байна. Санхүүгийн түрээсийн хүү болон даатгалын зардалд 139.2 сая төгрөг төлөхөөр гэрээ байгуулсан байна.
- ✓ Монгол Улсын Сангийн яамтай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээ /MON-P4, MON-P5/-гээр авсан урт хугацаат зээл, хүүгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулсан ба тайлант онд хүүгийн төлбөрт 883.2 сая төгрөгийг төлсөн байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит зар мөшлөг шалгах шаардлагатай дараах данснууд байна. Үүнд:

- ✓ Төлөөлөгчийн газрын тайлан



- ✓ Авлага, өглөгийн тооцоололт, түүний барагдуулалт
- ✓ Худалдан авалт, тендер
- ✓ Техник тоног төхөөрөмжийн сэлбэгийн орлого, зарцуулалт
- ✓ Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон бусад татварын тооцоололт зэргийг дахин нягталж үзэх шаардлагатай
- ✓ Компанийн үр ашиг, үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийх шаардлагатай.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

“Шивээ-овоо” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд аудитаар нийт 13 төрлийн 3,457.3 сая төгрөгийн алдаа илэрсэнээс 6 төрлийн 2,447.2 сая төгрөгийн гүйлгээг залруулсан. Мөн 4 төрлийн 991.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөхөөр менежментийн захидал хүргүүлсэн. 3 төрлийн 18.4 сая төгрөгийн зөрчил, мөн санхүүгийн тайланг хоцроосон, үндсэн хөрөнгө худалдан авах, данснаас хасахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8-д заасныг зөрчсөн зэрэг зөрчилд нийт 3 албан шаардлага хүргүүлсэн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд “Есөн хангай аудит” ХХК-ийн хийсэн аудитаар 4 зөвлөмж өгөгдсөн бөгөөд эдгээр зөвлөмжөөс бүрэн биелсэн 2, бүрэн хэрэгжээгүй 2 зөвлөмж байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгов.

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 2 хувиар тооцож 1,037.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид “Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгыг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Шивээ-Овоо” ТӨХК-ийн 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь “Шивээ-Овоо” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 МӨНГӨН ХӨРӨНГИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Хас банкны 5000094701 тоот төгрөгийн, Төрийн банкны 30030008438 тоот төгрөгийн, 341033090506 тоот төгрөгийн, 34130322697 тоот ам.долларын, 300300131348 тоот рублийн дансууд аж ахуйн нэгжийн гэрчилгээнд тэмдэглэгдээгүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “хуулийн этгээд нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан бүртгэлийн мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасныг хэрэгжүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлтийг бүртгүүлэх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 4 дүгээр сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Компанийн тухай хуулийн заалт зөрчигдөх

Батламж мэдэгдэл: (Эрх ба үүрэг, тохиолдсон байх, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал)

Үйлчлүүлэгчийн хариу

Улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэлгүй данснуудыг 2018 оны 3 сарын 31-ний дотор бүрэн бүртгүүлнэ.



3.2 Авлага, өглөгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

- ✓ Авлагыг Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын дагуу ангилаагүй.
- ✓ Өмнөх оны авлагын үлдэгдлийг барагдуулаагүй нийт 21 харилцагч байгууллагын 560.6 сая төгрөг /хавсралтаар/-ийн авлага байна.
- ✓ Найдваргүй авлагын нөөц данс нь 3,191.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд өмнөх жилүүдэд борлуулалтын орлогын дүнгээс тодорхой хувиар тооцож хуримтлуулан бүртгэдэг байсан байна. Шүүхийн шийдвэртэй 320.1 сая төгрөгийн авлага байгаа боловч барагдуулах арга хэмжээг аваагүй байна.
- ✓ Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 52.9 сая төгрөг, Ус ашигласны төлбөр 4.8 сая төгрөг, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 39.9 сая төгрөг, Хувь хүний орлогын албан татварын өглөг 3.6 сая төгрөгөөр тус тус татварын тайлангийн үлдэгдлээс зөрсөн.
- ✓ Урьдчилж гарсан зардал дансанд өмнөх тайлант жилд үүссэн 37 аж ахуйн нэгжийн 409.3 сая төгрөг /хавсралт/-ийн урьдчилж төлсөн тооцоог барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “*нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*”, 20.2.5 “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэж тус тус заасныг, мөн Сангийн сайдын 249 дүгээр тушаалын заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн хуулийн заалт зөрчигдөж, санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх үүрэг батламжийн мэдэгдлүүд зөрчигдөх;

Батламж мэдээгдэл: (Эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал)


ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 4 дүгээр сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Баталгаажаагүй авлагын үлдэгдлийг 2018 оны 3 сарын 31-ний дотор бүрэн тооцоо нийлж дуусгана.



3.3 Цалин хөлс, ХХОАТ, НДШ-ийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

Цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлан” /ТТ-11/ болон “Суутгагчийн хувь хүнд олгосон орлогын албан татварын тайлан” /ТТ-12/ маягтаар тайлагнадаг. Нийт суутгасан 814.1 сая төгрөгийн татвараас дээрх 2 тайлангаар 795.8 сая төгрөгийн татвар тооцоолж 18.3 сая төгрөгийн татварын ногдуулалтыг дутуу тайлагнасан байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2-д “Энэ хуулийн 24.1-т заасан хөнгөлөлтийг хасч, холбогдох төсөвт шилжүүлнэ” гэж заасныг зөрчсөн ба мөн санхүүгийн тайлангийн үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Хувь хүний орлогын албан татвар, Нийгмийн даатгалын тухай хууль түүнийг тайлагнах заавар журмын дагуу, цалин болон цалингаас суутгасан ХХОАТ, НДШ-ийн зөв тайлагнаж татвар болон шимтгэлийн тайлантай нийцүүлэн санхүүгийн тайланг гаргаж байх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 4 дүгээр сарын 05-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Татварын тайлангаар алданги хүлээх, санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх,

Батламж мэдэгдэл: (Эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал)

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.



3.4 БАРАА МАТЕРИАЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №4

ҮАГ-ын ажиглалт

- ✓ Бараа материалын нэр төрлөөрх дэлгэрэнгүй тайланг шалгахад хасах үлдэгдэлтэй бараа материал их байна. Энэ нь эд хариуцагч болон нягтлан бодогчид санхүүгийн програмд хасалт хийхдээ нэр төрлийн кодыг зөрүүлж бүртгэснээс шалтгаалсан байна.
- ✓ Тайлант онд хөдөлгөөн хийгдээгүй 7,271.0 сая төгрөгийн сэлбэг, бараа материал байгаа бөгөөд энэ нь нийт бараа материалын 56.4%-ийг эзэлж байна. Ашиглагдахгүй байгаа сэлбэг, бараа материалыг худалдан борлуулахаар туршин үзсэн бөгөөд зохих үр дүнд хүрээгүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.2-т заасан *“бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх”* гэж заасныг зөрчсөн.

ҮАГ-ын зөвлөмж

Компанийн тухай хууль, холбогдох стандарт, заавар журам, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөх, санхүүгийн тайланд тусгагдсан бараа материалын үлдэгдлийг дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгаж зөрүү гарсан бол санхүүгийн тайлан батлагдахаас өмнө залруулж, үлдэгдлийг тохируулж байх, эд хариуцагч болон санхүүгийн ажилчдын ур чадварыг нэмэгдүүлэх зэрэг зөвлөмж өгөв.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 4 дүгээр сарын 05-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Бараа материалын үлдэгдлийг шалгаж хянаагүйгээс санхүүгийн тайлан буруу гарах, өмч хөрөнгө шамшигдах, хохирол учрах эрсдэлтэй.

Батламж мэдэгдэл: (Оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал)

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.



3.5 ЗАРДЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №5

ҮАГ-ын ажиглалт

Нийт зардал 51,351.9 сая төгрөгт хүрч өмнөх оноос 7,544.1 сая төгрөг буюу 17.2%-иар, төлөвлөсөнөөс 7.0%-иар буюу 3,385.9 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Зардал хэтэрсэн шалтгаан нь 2017 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй ус шүүрүүлэх Д шугамын төслийн ажлыг хийж гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

Удирдлагын зардал өмнөх жилээс 811.0 сая төгрөгөөр, төлөвлөгөөнөөс 818.6 сая төгрөгөөр хэтрэлттэй байна. Зардал хэтэрсэн шалтгааныг компанийн зүгээс борлуулалтын орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор төлөвлөгдөөгүй болон тодотголд тусгагдсан зардлууд гарсан гэж тайлбар ирүүлсэн. 2017 оны бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан боловч Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл ийн 21.1-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид “зорилтын санал” гэх/-ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”, Компанийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.5.9 “Гүйцэтгэх удирдлагаас боловсруулсан компанийн ирэх санхүүгийн жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, нэмэлт өөрчлөлт оруулан шийдвэрлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Төлөвлөгөөг оновчтой хийгээгүйгээс хэтийн зорилтыг буруу тодорхойлох эрсдэлтэй.

Батламж мэдэгдэл: (Эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал)

ҮАГ-ын зөвлөмж

Компанийн бизнес төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд, Компанийн дүрэмд заасныг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөв.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 8 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Цаашид хэрэгжүүлж ажиллана.




4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2017.01.01	2017.12.31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгөн хөрөнгө	1,626,263,897.18	815,127,904.04
Дансны авлага	1,596,507,331.42	6,198,433,095.04
Найдваргүй авлагын хасагдуулга	0.00	(3,191,012,968.00)
Татварын авлага	10,225,896.43	994,836,177.32
Бусад авлага	1,268,236,156.64	229,447,407.73
Бараа материал	14,006,850,447.60	13,558,722,650.87
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	2,312,477,070.07	3,341,574,510.83
Эргэлтийн хөрөнгийн дүн	20,820,560,799.34	21,947,128,777.83
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	69,642,998,281.46	63,294,939,428.62
Биет бус хөрөнгө	0.00	30,105,642.78
Хөрс хуулалтын хөрөнгө	24,752,768,431.94	31,173,428,322.61
Хойшлогдсон хөрс хуулалтын шавхагдал	(1,871,222,945.66)	(2,056,467,925.00)
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	530,131,395.36	500,025,752.62
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,304,460,207.09	1,306,537,193.78
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	94,359,135,370.19	94,248,568,415.41
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	115,179,696,169.53	116,195,697,193.24
ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	20,374,564,485.82	22,485,866,580.58
Цалингийн өглөг	296,388,886.57	396,497,017.11
Татварын өр	842,653,688.98	2,592,782,333.28
НДШ-ийн өглөг	335,534,666.96	299,496,292.26
Санхүүгийн түрээсийн хүүгийн өглөг	317,149,520.07	-
Ногдол ашгийн өглөг	130,419,101.00	13,041,910.00
Урьдчилж орсон орлого	0.00	12,219,005.47
Засгийн газрын дэмжлэг	3,637,483,376.00	2,193,778,389.73
Бусад богино хугацаат өр төлбөр	26,526,442,965.92	30,040,197,668.93
Санхүүгийн түрээсийн өглөг	5,061,669,186.60	5,198,808,779.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	57,522,305,877.92	63,232,687,976.36
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	16,544,200,248.18	13,937,326,403.09
Засгийн газрын дэмжлэг	20,392,768,722.69	20,392,768,723.00
Ажилчдын тэтгэврийн сан	1,267,620,924.52	1,373,207,370.63
Санхүүгийн түрээсийн өглөг	10,502,656,315.94	10,297,427,085.26
Санхүүгийн түрээсийн хүүгийн өглөг	2,228,477,879.80	0.00
Хойшлогдсон татварын өр	358,564,643.00	358,564,643.00
Урт хугацаат өр төлбөрийн дүн	51,294,288,734.13	46,359,294,224.98
Нийт өр төлбөрийн дүн	108,816,594,612.05	109,591,982,201.34
Эзэмшигчдийн өмч	1,341,900,000.00	1,341,900,000.00
Өмч: - Төрийн	1,207,710,000.00	1,207,710,000.00
- Хувийн	134,190,000.00	134,190,000.00
Хуримтлагдсан ашиг	5,021,201,557.49	5,261,814,991.90
Эзэмшигчдийн өмчийн дүн	6,363,101,557.49	6,603,714,991.90
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	115,179,696,169.54	116,195,697,193.24



4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /төгрөгөөр/
Борлуулалтын орлого	42,752,185,435.10	50,359,237,159.66
Борлуулалтын буцаалт	0.00	1,297,050,976.23
Цэвэр борлуулалт	42,752,185,435.10	49,062,186,183.43
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	35,177,815,503.58	41,755,281,943.93
Нийт ашиг (алдагдал)	7,574,369,931.52	7,306,904,239.50
Засгийн газрын тусламж	0.00	1,443,704,986.30
Хүүний орлого	0.00	18,548,234.55
Бусад орлого	3,145,926,388.65	1,041,247,175.31
Борлуулалт, маркетингийн зардал	0.00	1,493,640,023.21
Ерөнхий удирдлагын зарлал	2,842,753,633.17	3,832,462,273.03
Бусад зардал	1,179,560,514.21	557,611,061.43
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз/	0.00	0.00
Санхүүгийн зардал	0.00	0.00
Хүүгийн зардал	4,189,150,683.80	3,653,420,753.47
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)	(186,309,345.90)	0.00
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		0.00
Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз гарз)	0.00	0.00
Бусад ашиг (алдагдал)		0.00
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,322,522,143.09	273,270,524.52
Орлого татварын зардал	232,252,214.31	32,741,090.44
Татварын дараах ашиг (алдагдал)	2,090,269,928.78	240,529,434.08
Цөөнхөд ноогдох хувь		
Ердийн шинжтэй зүйлс - цэвэр		
Онцгой шинжтэй зүйлс - цэвэр		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,090,269,928.78	240,529,434.08
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Орлогын нийт дүн	2,090,269,928.78	240,529,434.08
Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)		



4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1,341,900,000.00	3,335,751,599.74	4,677,651,599.74
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө		(274,400,870.00)	(274,400,870.00)
3	Залруулсан үлдэгдэл	1,341,900,000.00	3,061,350,729.74	4,403,250,729.74
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		2,090,269,928.78	2,090,269,928.78
5	Бусад дэлгэрэнгүй орлого			0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт		(130,419,101.02)	(130,419,101.02)
7	Зарласан нодол ашиг			0.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			0.00
9	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,341,900,000.00	5,021,201,557.50	6,363,101,557.50
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө		84,000.33	84,000.33
11	Залруулсан үлдэгдэл	1,341,900,000.00	5,021,285,557.83	6,363,185,557.83
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		240,529,434.07	240,529,434.07
13	Бусад дэлгэрэнгүй орлого			0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт			0.00
15	Зарласан нодол ашиг			0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			0.00
17	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,341,900,000.00	5,261,814,991.90	6,603,714,991.90




4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	42,300,490,611.01	44,434,349,613.15
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	41,439,880,308.37	44,232,950,074.85
	Туслах үйл ажиллагаанаас олсон орлого	860,610,302.64	201,399,538.30
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
	Бусад мөнгөн орлого	0.00	0.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	38,638,328,383.61	47,100,233,837.39
	Ажиллагсад төлсөн	6,192,843,925.43	5,468,439,952.10
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,074,942,452.00	2,174,716,045.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	17,613,866,437.56	29,786,390,286.20
	Ашиглалтын зардалд төлсөн	6,602,597,647.06	5,044,426,455.94
	Түлш шатахуун, тээврийн хэрэгсэл, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	0.00	0.00
	Хүүний төлбөрт төлсөн	533,295,741.59	179,046,303.43
	Татварын байгууллагад төлсөн	4,359,190,782.21	3,047,709,352.26
	Даатгалын төлбөрт төлсөн	57,765,116.21	108,401,322.40
	Бусад мөнгөн зарлага	1,203,826,281.55	1,291,104,120.06
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,662,162,227.40	(2,665,884,224.24)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	438,525,227.00	0.00
	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	438,525,227.00	0.00
	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	0.00	0.00
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
	Хүлээн авсан хүүний орлого	0.00	0.00
	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,235,000,000.00	0.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	3,235,000,000.00	0.00
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Бусад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.3.	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,796,474,773.00)	0.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
	Мөнгөн орлогын дүн (+)		
3.5	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргасанаас хүлээн авсан	5,612,458,381.46	7,545,856,240.29



	Хувьцаа болон өмчийн үнэт цаас гаргасанаас хүлээн авсан	0.00	7,993,226.59
	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
	Валютын ханшийн зөрүү	4,651,694.29	0.00
3.6	Мөнгөн зарлагын дүн (-)	6,899,730,467.17	5,691,108,009.20
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	6,816,224,679.17	3,500,000,000.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	55,200,000.00	2,134,799,999.98
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	28,305,788.00	0.00
	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
	Төрөл бүрийн хандив	0.00	15,241,748.00
	Валютын ханшийн зөрүү		41,066,261.22
3.3.	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,282,620,391.42)	1,854,748,231.09
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(416,932,937.02)	(811,135,993.15)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,043,196,834.20	1,626,263,897.18
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,626,263,897.18	815,127,904.04

